

# МОНГОЛ БА СОЛОНГОСЫН ШАШИН, СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

Д. Цэдэв

Монгол ба Солонгосын шашин, соёлын уламжлал, түүний хэлхээ холбооны зарим асуудалд анхаарлаа чиглүүлэн өгүүлэхүйн урьд монголчуудын язгуурын түүхийн сурвалж бичгийн мэдээгээр солонгосчуудын нэрийн гарбалд «тө. Kalinga» буюу «Уран хачин» хэвээх шувууны нэрээр «Солонгос»-ын нэрийг улираан тэмдэглэж ирсэн уламжлал мөн тэрээр монголчууд чухам яагаад «Солонгос» гэж нэр дуудах болсон явдлыг дотоод, гадаадын эрдэмтэн мэргэдийн бүтээлд дурдсан мэдээ баримтыг харгуулан сэргээвээс, үүнд:

Монголын эрдэмтэн Сумадираднаа (Лувсанрэнчин, 1821) «тө. Kalinga»-г<sup>1</sup> Солонгос, Ю. Н. Перрих (Орос) «тө. Kaling-gaba»-г<sup>2</sup> (Корейское подворье, The Korean rest-house, Солонгосын сэрүүн өргөө), Иандра Дас (Энэтхэг) «Бурхадын арилсан (ариун) 36 орны нэг, Төгс баясгалант (Tusita) тэнгэрийн орон»-оор<sup>3</sup> нэрлэн зааж, мөн Санскрит-Хятад-Англи-Тайланд хэлээрх бурханы шашны толь бичиг»-т «kukku-tuse-vaḡa» (Солонгос), «Henguli» (Солонгос) гэж нэр зааж тэмдэглэсэн байгаа ажээ.

Бидний бодоход түүхийн хувьд ч «тө. Kalinga» «Мо. Солонгос» гэдэг хоёр нэр, нэг нэр байх бүрэн үндэстэй болох нь дээр дурьдсан нэр, утгын олон холбоосоор батлагдаж байгаагаас гадна «Kalinga» буюу «Мо. Уран хачин» нэрт тэр шувуу ганцхан «Kalinga» гэдэг аралд байгаа, ер бусын сайхан дуутай, түүний дууг сонсох амьтан, хүн зөвхөн үүрийн цолмонгоор л сонсохын учирт монголчууд «Солонгос» хэмээх нэрийн язгуурын гарбалыг олон монгол аялгуу буриадаар «үүрэ толон» (үүрийн цолмон), «Толон» (цолмон), «Толонгод» (тод гэрэл) бу-

---

Д. Цэдэв —Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

юу «Тод цагаан», «Тод» «Сод» мэт эдгээр нэрийн язгуурт холбож «Үүрийн цолмон»-гоор үлгэрлэн «Цагаан Солонгос» хэмээн нэрлэсэн гэж хууччуул ч өгүүлэх ёс байдаг нь дээрхийг давхар баталж байна гэлтэй.

Сайхь бидний өгүүлэн буй мэдээнд «Tusita»-г «тө. dqa Ldan»<sup>6</sup> (Төгс баясгалант) тэнгэрийн орны нэрийг зааж «Солонгос»-ыг үлгэрлэн үүнийг гагцхүү бурханы шашны сургаалын үүднээс сансар шүтлэгийн онолын үндэс» Mile hsia shengching гэдэг солонгосын сударт дурдахдаа:

«Майдарын тэгээн «Tusita» (Төгс баясгалант) тэнгэрийн орноос газар дэлхийд заларч»<sup>8</sup> бөгөөс Солонгосын хаадын язгуурын дамжлагыг «Номын хүрдэн орчуулагч хаан»<sup>9</sup> (Sakravartin) гэж «Chinghung»<sup>10</sup> хаанаас эхлэн өгүүлэхүйн учирт «Солонгос»-ыг «Tusita» (Төгс баясгалант)-ын орон хэмээх уламжлалтай болой.

Ази дорнодахин түүний дотор монголчууд «Солонгос» хэмээн нэрийг өгүүлэхүйн ийм түүхтэй ажээ.

Бурхны шашин ер нь Ази тив түүний дотор Төв Азийн олон төр улсын төр ёсны уламжлал, түүний соёл, иргэншлийн хэмжээнд Энэтхэг оронд үүсгэл түүхтэй бурхан багшийн МЭӨ (565—490—480) сургаал, шашин, соёл хүннү (тө. hor) нарын дунд «Бурхан нирван дүр үзүүлснээс хойш 180 жилийн дараа»<sup>11</sup> эртний Хотан (Li uls) лугаа нэгэн зэргээр шууд Энэтхэг орноос нэвтрэн ирсэн гэж үздэг.

Монголын эрдэмтэн гүн Гомбожавын (ХҮП зууны сүүл хагас, ХҮШ зууны эхэн хагас) «Хятад оронд бурхны шашин дэлгэрсэн түүх» гэдэг зохиолд Хүннү нарын «Алтан бурхан»-ы<sup>12</sup> тухай өгүүлэхдээ: «Хүннү нарын эд агуурсан дотроос алтан бурхан олзлон аваад тэрийг Хан улсын эзэн Ү-ди (МЭӨ 140—87) хааны дотоод ордонд «Чухаг дээд гурав»-ын (бурхан, ном, хуварга гэж Д. Ц) шүтээний анх болгон залав»<sup>13</sup> гэх буюу харин тэрээс хожуу үе «Минди хаан (МЭ 58—75)-ы Юн-пингийн 8-р онд Хятад оронд бурхны «шашин төв»-ийг (төрийн шашин) гэж Д. Ц) байгуулав»<sup>14</sup> гэж буй нь хүннү нар хятадын Хан улсаас ихээхэн түрүү бурхан шашинтай танилцсан болохыг харуулж байна.

Ер нь бурхны шашин эртний Монгол газарт Дорнод Туркестаны өмнөт хэсэг болох Хотангаас умар зүгийн говь нутгаар орж ирсэн тухай эрдэмтдийн санал ерөнхийдөө нийлж байгаа юм. Тухайлбал, Монголын түүхч эрдэмтэн Ш. Дамдины (1867—1937) «Алтан дэвтэр»-т<sup>15</sup> дэвшүүлсэн сонирхолтой санал Хатана Рётайгийн «Баруун газар ба бурхан шашин» гэдэг зохиолд «МЭӨ III зууны сүүл хагасаас бурхны шашин Афганистан, Перс, баруун, зүүн Турстанд хурч байв»<sup>16</sup> гэж өгүүлсэнтэй он цаг, түүхийн хувьд ч эргэлзээгүй мэт.

Солонгосын оронд бурхны шашин, соёл нэвтэрч байсан тухай Монголын эрдэмтэн гүн Гомбожавын (ХҮП зууны сүүл хагас, ХҮШ зууны эхэн хагас) «Хятад оронд бурхны шашин дэлгэрсэн түүх» гэдэг зохиолд дурдсан мэдээг зорнод бүрэн орчуулгаар<sup>17</sup> авъяу, үүнд:

«Хуушан (hwa gan) өлмий цагаан хамба» гэж нэрд гарсан, алдар нэр Тан-ша хэмээх нэг, аягаа тахимлагын боолт (санваар) төдийд бүтээлийн шинжийг (гайхамшиг) гаргаж чадсан тэр; Монголын хаан (тө. соq) овгийн хуварга эм байсан түүнийг алаачинг сорьж үзэхээр хүргэсэн тул; Хаан хилэгнэж мэс элдэв зүйлийг өргөсөн боловч хорлол эс гарсанд сүслэх бөгөөс банди (лам) тэрийг алахгүй гэж тангараг өргөв.

Тэрээр орон зонхид (солонгос гэж Д. Ц) тойн хуварга тоолшгүй болж үл айхын авралын өглөгийн эзэн болов.

Урьд Солонгосын оронд ялгуусны шашин нэрийн төдий үл алдаршсанд Ловон (Өлмий цагаан хамба) тэр гурван аймаг саван судар боть

(praiana paramita Perfection wisdom, Madhya mika (Middle path), Abhidharma. олонтойг авч ирсэн тул ялгуусны шашны хууль шинэ тулгарыг (төрийн шашин гэж Д. Ц) тогтоов»<sup>18</sup> гэжээ.

Чингэхүл, бидний өгүүлэн буй «Өлмий цагаан хамба» буюу «Тан-ша» хуушаны тухай солонгос сурвалжийн 2 баримтыг өгүүлмүй. Үүнд: Introduction of Buddhism to Korea» гэдэг зохиолд; «Тан-ша» (t'anshih) бол Дорнод Цзинь (Ch'in) улсын лам Когурёгын эзэн хаан Кванчгайто (Kwanggaeto) (391—413) түүний хаанчлалын үед Лян-дун мужид хүрч очихдоо бурхны шашны судар боть олонтойг залж ирсэн»<sup>19</sup> гэжээ.

Тэрээр Солонгос улсын Duk whong Kim «A history of Religion» гэдэг зохиолдоо: «Дорнод Цзинь (Ch'in) улсын хуушан Тан-ша (T'an shih) бол Когурёгын эзэн хаан Кванчгайто түүний ширээнд суусны 5-р онд Когурёгын оронд бурхны шашны судар боть олонтойг урин залж ирсэн буюу «Өлмий цагаан хамба» гэж хүндлэн өргөмжлөв»<sup>20</sup> гэжээ.

Бидний өгүүлэн буй эл 3 сурвалж мэдээгээр Цзинь улсын «Өлмий цагаан хамба» буюу «Тан-ша» нэрт хуушан Когурёгын оронд бурхны шашны ном судар тавьж, судар боть олонтойг уриан залсан гэдэг дээр 3 сурвалжийн баримт ноттой болох нь харагдаж байна.

Чингэхүл дээр өгүүлснээр Солонгосын оронд бурхны шашныг албан ёсоор хүлээн авсан буюу төрийн шашны хэмжээнд өргөмжлөх зохиолдохын шалтгааныг зохиосон мэт Дорнод Цзинь (Ch'in) улсын «Өлмий цагаан хамба» буюу «Тан-ша» хуушан лугаа «Монголын хаан (тө. soq-gqyal) Хэляньбо бо» нь үйл явдал, баримтаар холбоотойгоор дурдагдаж байгаа болой. Үүнд:

а) Монгол, төвд сурвалж бичигт «Монгол»-ыг (тө. Sog) гэдэг нь угтаа Хүннү (тө. hog)-гийн<sup>21</sup> төрийг залгаж барьсан Монголын төрийн бүтэн нэрийг «Монгол» гэж өргөмжлөх болсныг нотолж байна.

б) «Хэляньбо бо» хэмээх нь чухам ямар түүхэн хүн болох эсвэл овог аймгийн нэр болохыг анхааран үзэхүл: хааны нэр биш бололтой, Ер нь монголын Хэрэйд аймгийн нэрээр цол өргөмжилсөн хаан буюу харин хятад сурвалж бичигт (Хэлань, хэлянь» гэж байдгийг эрдэмтэд «хэрэйд» аймаг мөн гэсэн нотолгоотой нэр, утга дүйж байна;

в) Монгол баруун этгээдээр эртний Энэтхэг, Баруун газрын орнууд, өмнөт биеэн талаар Хятад, дорно зүгээр эртний Солонгос зэрэг улстай хөрш зэргэлдээ оршиж байсан болохоор эдгээр улстай тогтоосон төрийн гадаад харилцаа, шашин соёлоор нэвтрэлцэх өргөн боломжтой заримдаа зуучлагчийн үүрэгтэй байсныг «Монголын хаан хэляньбо бо»-тай холбон үзэж болох мэтээ.

Ингэхэд Монгол, Солонгосын төр ёсны сургаал түүний алтан аргамж болон шашин соёлын харилцааны түүхийн асуудлыг өгүүлэхэд нэгэн үе «Азийн 100 үлэмж»<sup>22</sup> улс түмний соёл, соёл иргэншлийн хөгжлийн зангилаа голомт мэт. «Азийн тэргүүлэх их 16 улс»-д<sup>23</sup> багтаж байсан Монгол, Солонгос бол Азийн их соёлын түвшинд соёлын эртний уламжлалт хэлхээ холбоотой байсан юм.

Энэтхэг оронд түрүү гарсан «Номын хүрдэн орчуулагч хаад» буюу «Сакгавартин» хэмээх номлолын шашин-гүн ухааны үндэслэлд ялангуяа Монгол, Солонгосын төр ёсны сургаал «Их хөлгөний шашны» ёс болой.

1. Сумадарадна (Лувсанринчэн, 1821)-ийн «Төвд -Монгол дохионы бичиг», УБ. 1959. 1148 дэх тал.

2. Ю. Н. Перрих «Тибетско-Русско-Английский словарь с санскритскими параллелями». «Наука» Москва, 1983. 36 дахь тал

3. Chandra Das ;Tibetan-English dictionary» New Delhi. 1985, p. 11

4. A dictionary of Buddhism Chinese -Sanskrit-English-Tai. Bang—kok, 1976. p 472

5. Мөн 496 дахь тал.

6. Мөн 9, 459, 494 дэх тал.

7. Introduction of Buddhism to Korea. Berkley, California, 1989 p 16

8. Мөн 16 дахь тал.
9. Мөн 16 дахь тал
10. Мөн 16 дахь тал
11. Ш. Дамдин «Алтан дэвтэр», (төвд) Их хүрээ, 137 тал.
12. Гүн Гомбожавын «Хятад оронд шашин дэлгэрсэн түүх». ДДОУСХ фонд (25) дахь тал. Д. Цэдэвийн орчуулга.
13. Мөн 46 дахь тал
14. Мөн 57 дахь тал
15. Ш. Дамдины «Алтан дэвтэр» (Төвд), Хүрээ бар. 151 дэх тал
16. Баруун газар ба бурхны шашин. Шанхай, 1937, 47 дахь тал
17. Гүн Гомбожавын «Хятад оронд шашин дэлгэрсэн түүх», ДДОУСХ фонд (75 дахь тал) Д. Цэдэвийн орчуулга.
18. Мөн 63 дахь тал
19. Introduction of Buddhism to Korea. Berkley, California 1989, p 4
20. Dak, Whong Kim «A history of Religions in Korea»
21. Ишбалжирын «Галбарвасан модун», ДДОУСХ. фонд Д. Цэдэвийн орчуулга.
22. Гүн Гомбожавын «Хятад оронд бурхны шашин дэлгэрсэн түүх». ДДОУСХ фонд (1 дэх тал) Д. Цэдэвийн орчуулга.
23. Ш. Дамдины «Алтан дэвтэр». (төвд). Их хүрээ. 197 дэх тал